

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 12

1.	<i>Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	6 – 11
2.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/</i>	11 – 12

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
04 дүгээр сарын 30-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 41 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, Ц.Мөнхбат, У.Отгонбаяр;

Чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, М.Ганхүлэг, С.Лүндэг, М.Мандхай, Р.Сэддорж, Ж.Чинбүрэн.

Нэг.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Уртнасан, мөн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн дарга П.Цогтсайхан, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Д.Батмөнх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Ж.Батжаргал, З.Мэндсайхан нарын тавьсан асуултад Төрийн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг хариулж, тайлбар хийв.

Б.Бейсен: 1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 25.7 дугаар зүйлийг өөрчлөн найруулах:

“25.7.Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалах зайлшгүй шаардлагаар саарал чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 4

Бүгд: 14

71.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Замира, З.Мэндсайхан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 85.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Б.Бейсен: “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 11 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 19 минут үргэлжилж, 24 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 12 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Их засаг” танхим
11 цаг 41 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц 58.3 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааныг үргэлжлүүлэн хуралдаж байна.

Ирцийг танилцуулъя.

Буланы Бейсен 3 дугаар тойрог ирсэн байна, Очирын Амгаланбаатар 2 дугаар тойрог ирчихсэн байна, Тилеуханы Аубакир 3 дугаар тойрог ирсэн байна, Жигжидийн Батжаргал 5 дугаар тойрог ирсэн байна, Пүрэвийн Батчимэг жагсаалт ирсэн байна, Гомбын Ганбаатар 7 дугаар тойрог ирсэн байна, Сонгобайн Замира жагсаалт ирсэн байна, Цагаанхүүгийн Идэрбат 6 дугаар тойрог ирсэн байна, Мэндбаярын Мандхай гишүүн жагсаалт ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан 7 дугаар тойрог ирсэн байна, Загджавын Мэндсайхан 2 дугаар тойрог ирсэн байна, Бадрахын Найдалаа жагсаалтаар ирсэн байна, Нанзадын Наранбаатар 7 дугаар тойрог ирсэн байна, Агвааналувсангийн Ундраа гишүүн жагсаалт ирсэн байна, Болдын Уянгаа жагсаалт ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

Нэгдүгээрт, Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025 оны 03 сарын 14-ний өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг.

Хоёрдугаарт, Байнгын хорооны тогтоолын төсөл. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалд оръё.

Нэг.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн
мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ц.Уртнасан Төрийн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ц.Уранчимэг Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, П.Цогтсайхан Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн дарга, Д.Батмөнх Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх гэсэн ийм бүрэлдэхүүнтэй юм байна.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн Байнгын хорооны танилцуулгын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүд Та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгын төслийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулна.

Н.Наранбаатар гишүүний микрофоныг өгье.

Н.Наранбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатараас 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас төслийг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан зарчмын зөрүүтэй 2 саналын томьёоллийг бэлтгэн Та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

3.Мэндсайхан гишүүнээр тасаллаа. Н.Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Энэ чинь зарчмын зөрүүтэй ирүүлсэн саналаас асуулт асууж болох билүү? Дараагийнх нь уу?

Б.Бейсен: 3.Мэндсайхан гишүүн асуулт асууя.

3.Мэндсайхан: Би Н.Наранбаатар гишүүнтэй адилхан л юм асуух гээд байна л даа. Энэ 25.8 гээд зарчмын зөрүүтэй санал. Үүнийг л асуух гэсэн юм.

Б.Бейсен: Асуулт зарчмын зөрүүтэй саналтай давхацсан учир энэ асуулт асуугаад дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар 2 саналын томьёолол ирүүлсэн байгаа.

Нэгдүгээр санал. Төслийн 1 дүгээр зүйл буюу 25.7 дугаар зүйлийг өөрчлөн найруулж 25.7, 25.8 дахь хэсэг болгох:

“25.7.Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалах зайлшгүй шаардлагад саарал шөнө агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй.

25.8.Энэ хуулийн 25.7-д заасан нөхцөл байдал өссөн бол 24 цагт багтаан сумын байгаль хамгаалагчид мэдэгдэж, холбогдох нотлох баримтын хамт бүртгүүлэх бөгөөд тухайн агнасан ангийн гаралтай түүхий эдийг худалдан борлуулах, бусдад шилжүүлэхийг хориглоно.” гэсэн заалт байна.

Саналын томьёололтой холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Гишүүд нэрсээ өгнө үү.

Ж.Батжаргал гишүүнээр тасаллаа. Н.Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Саналын томьёоллын 25.8 дахь заалтыг хаанаас нэмсэн юм бол? Ямар утга агуулгатай, яагаад энд орж ирсэн юм бол.

Энэ чинь хэд дэх хэлэлцүүлэг билээ? Миний гаргасан саналын томъёолол биш шүү дээ. Би 25.7-г гаргасан. Тэгээд 2 дугаар зүйлийн тэр 6 сарын 01 гэдгийг л гаргасан шүү дээ. Энэ заалт яагаад орж ирж нэмэгдсэн юм бол?

Б.Бейсен: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Ц.Уранчимэг: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг байна. Гишүүний асуултад хариулъя.

Яг энэ заалтыг нэмж оруулсан санал нь өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалж, зайлшгүй шаардлагаар чоно агнасан гэдгээ бүртгүүлэхгүй бол одоо Амьтны тухай хууль дээр байгаа заалтаараа бас Зөрчлийн хууль, Эрүүгийн хуулиар шалгагдаад хэн нэгэн хүн матах юм уу, ямар нэгэн асуудал үүсэх юм бол шалгагдаад эрүүгийн хариуцлага үүрэх шат руу явах боломжтой учраас энэ заалтыг тухайлан оруулж өгч байж, яг энэ өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалж зайлшгүй шаардлагаар энэ чоныг агнасан гэдгийг нь нотлоод, тэгээд экологийн цагдаа тухайн орон нутагтаа бүртгэгдээд Байгаль орчны яаман дээр жилд яг ийм тохиолдлуудын тоог бас амьтны мэдээллийн сандаа нэгтгээд явах зорилгоор оруулсан байгаа.

Мөн агнасан ангийн гаралтай түүхий эдийг худалдан борлуулах, бусдад шилжүүлэхийг хориглодог.

Яагаад гэхээр зөвшөөрөл аваад ахуйн, үйлдвэрийн зориулалтаар чоно агнасан бол зэрлэг амьтан, ургамлын худалдаалах **CITES** [The Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora]-ийн конвенцын тухай хуулиар бас худалдаалах, борлуулах үйл ажиллагааг нь зохицуулдаг учраас энэ заалтад хамаарахгүй гэдгийг нь зааж өгсөн байгаа.

Б.Бейсен: Ж.Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Үгүй энэ одоо бас дэгээ л анзаармаар байна л даа.

Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бүрэн эрхийнхээ дагуу гишүүн өргөн барьсан байхгүй юу. Хэлэлцүүлгийн явцад энд нэг гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргасан байхгүй юу.

Үгүй ээ, тэгээд энэ хоёр хүн нь тэр наад 8 дахь заалтыг чинь ерөөсөө мэдэхгүй байгаад байна шүү дээ.

Тэгэхээр хэн нэмдэг юм? Тэгж болдог юм уу? Явц дунд нь нэмдэг юм. Үгүй тэр ч болохгүй шүү дээ. Засгийн газраас өргөн барьсан бол төсөл өргөн баригч асуудалд хандаж гэдэг юм уу, юм ярьж болно. Эсвэл ажлын хэсэг тусдаа байгуулагдсан бол дэд ажлын хэсгийнхээ санал дээр тулгуурлаж асуудлаа ярих бололцоо бий.

Энэ чинь одоо эзэн биегүй юм хууль дотор давхиж орж ирдэг болж хувирах гэж байна шүү дээ. Үүндээ нэг тов тодорхой тайлбар авмаар байна.

Тэгээд ер нь бол яг нарийндаа яах вэ 25.7 чинь яригдахаар асуудал биш шүү дээ, уг нь.

Би 2 дугаар зүйлийг нь л гүйцээн боловсруулахаар чиглэл өгөгдсөн гэж ойлгоод байгаа шүү дээ. Чуулганы нэгдсэн хуралдаан дээрээс.

Б.Бейсен: Байнгын хорооны ажлын хэсэг хуулийн зөвлөхтэй хамтраад зөвлөгөө авчхаач. Ажлын хэсэгтэй зөвшилцөөд оролцсон байна. Хариулахгүй юм байна уу? Манайхаас. Н.Наранбаатар гишүүн наадхаа танилцуулаад. Эцсийн хэлэлцүүлэг учраас.

Н.Наранбаатар гишүүний микрофоныг өгье.

Н.Наранбаатар: Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд тэр 25.7 гэсэн нэг заалт, 2 дугаар зүйл хоёрыг л зарчмын зөрүүтэй санал оруулж түрүүчийн хурал дээр батлуулсан учраас 25.8-ыг би оруулаагүй. Дэмжихгүй байгаа юм.

Б.Бейсен: 3.Мэндсайхан гишүүн асуулт асууя.

3.Мэндсайхан: Миний асуулт ерөнхийдөө давхцаад байна.

Энэ хуулийг яг үндсэн хоёр гишүүний өргөн барьсан үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа юм. 25.8 дээр 24 цагт багтаана, ийм ийм гээд заалт хууль санаачилсан зарчмын зөрүүтэй санал гаргасан хоёр гишүүн маань хоёулаа оруулж ирээгүй гэж байгаа. Энэ саналыг дэмжих боломжгүй ээ.

Ер нь зүгээр тэр дэгээ барья гэдэг асуудал дээр яагаад та нар үүнийг оруулж ирж байгаа юм бэ? Энэ эрх та бүгдэд байдаг юм уу? Их Хурлаар хэлэлцэгдсэн асуудлыг та нар дундуур нь ийм асуудал шургуулаад Байнгын хороогоор хэлэлцүүлэх гээд сууж байна. Энэ дээр хариуцлага байдаг юм уу? Ийм байдлаар асуудалд хандаж болох юм уу? Энэ дээр Байнгын хорооны дарга, одоо ажлын хэсэг гэж ойлгох юм уу? Та нарыг чинь. Энэ дээр хариулт өг.

Хоёрдугаарт, энэ чононоос гадна нэг асуудал байна. Ховд аймагт. Байгаль орчны яамныхан байгаа учраас. Ондатра^[nat.Ondatra zibethicus] гэж нэг амьтан байна. “Зарт харх” гээд.

Тэр Хар ус нуурын ай сав газар, тэнд нутаглаж амьдарч байгаа хүмүүсийн амьдрал ахуйд үгүй мөн их зовлон болж байна.

Тэгээд энэ амьтныг ер нь зохистой, байгальд тэнцвэртэй байдлыг нь хадгалах тал дээр Байгаль орчны яам ямар бодлого барьдаг юм бэ? Одоо тэнд байгаа Хар ус нуурыг дагасан тэр арлууд чинь бүгд живээд дууслаа.

Айлын өвөлжөө байхгүй болчихоод байна шүү дээ. Усан доогуур яваад орчхож байна.

Тэгээд энэ асуудлыг ер нь ямархуу бодлого барьж байгаа юм? Яаж эдийн засгийн эргэлтэд оруулах юм? Энэ дээр ямар нэгэн тийм эдийн засгийн зохицуулалт хийхгүй байгаа учраас тэрийг хүмүүс агнахгүй байна. Ингээд одоо тэр ондатрыг хэчнээн л малгай хийж өмсөв гэж дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээр ямар бодлого барьж байна аа?

Б.Бейсен: 6 номер хариулъя.

Ц.Уранчимэг: 3.Мэндсайхан гишүүний асуултад хариулъя.

Ондатра бол анх. Ер нь бол харь зүйл амьтан. Анх яг нутагшуулсан зорилго нь ан агнуурын зориулалтаар нутагшуулсан ийм амьтан байгаа.

Тэгээд ондатрын яг энэ асуудлыг Ховд аймаг дээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас С.Бямбацогт гишүүн бас Засгийг газраар үүнийг хэлэлцээд, тэгээд тусгай зөвшөөрлийг нь.

Яагаад шууд агнаж болохгүй байдаг вэ гэдэг асуудал нь тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсэд хамаарагддаг бүс нутаг дотор байдаг.

Гэхдээ үүнийг тоо толгойг нь зохицуулах байдлаар тусгай зөвшөөрлийг нь өгөөд тодорхой хэмжээнд зохицуулалт хийсэн. Гэхдээ энэ асуудал нь дахиад тухайн орон нутгийн байгаль орчны газар дээр асуудал нь нээлттэй байгаа.

Харь зүйлийн амьтны тоо толгойг зохицуулах, устгах, цөөрүүлэх гэдэг заалт нь бас амьтны хуулиар зохицуулалт хийгээд явж байгаа. Боломжтой. Тийм.

Б.Бейсен: Энэ 25-ын 8 дахь санал дээр Их Хурлын даргаас бас чиглэл өгсөн юм.

Яагаад гэвэл галзуурсан чонотой холбоотой, бас түүхий эдийг нь борлуулахгүй ингээд шинжилгээ нь гартал.

Тийм учраас манай Байнгын хорооны санал байсан. Тийм учраас хууль санаачлагч болон гишүүдийн саналыг үндэслээд 25.8-ыг хасаад, зөвхөн 25.7-гоор санал хураалт явуулъя. Тийм. 25.7 дээр л.

Дахиад уншаад танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйл буюу 25.7 дугаар зүйлийг өөрчлөн найруулах:

“25.7.Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалах зайлшгүй шаардлагаар саарал чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй.” гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

С.Замира гишүүн, З.Мэндсайхан гишүүн хоёрыг дэмжсэнээр авлаа.

Санал 71.4 хувиар дэмжигдлээ.

Хоёр дахь санал. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2025 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн санал хураалт. Дэмжсэнээр оруулъя.

85.7 хувиар дэмжигдлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Н.Наранбаатар гишүүн танилцуулна.

Хоёр дахь асуудал.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/

Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг, П.Батчимэг нар Байнгын хорооны 2025 оны 07 дугаар тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлын 2022 оны 36 тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцах, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллах талаар хүсэлтийг тус Байнгын хороонд ирүүлсэн байгаа.

Энэ бас нэг юм сануулахгүй бол болохгүй байна. С.Лүндэн гишүүн хуралд ирэхгүй байна. Санал гаргачаад. Тэрийг бас дамжуулж хэлээрэй. Манайхан. Өчигдөр бас ирээгүй. Өнөөдөр байхгүй. Тэгэхдээ энэ хүсэлт гаргасан юм чинь гишүүний бүрэн эрхийн хүрээнд оруулахаас өөр аргагүй.

Тогтоолын төслийг танилцуулъя.

“Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын

Хяналт, шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 07 дугаар тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлын 2022 оны 36 тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, С.Лүндэг нарыг нэмсүгэй гэсэн тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслийг баталъя. Санал хураалт. /алх цохив/

78.6 хувиар дэмжигдсэн байна.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүдэд баярлалаа.

Хуралдаан 19 минут үргэлжилж, 12 цаг 00 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД